



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/312

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/б/, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит V хуралдааны 5/03 тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Багийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн удирдлагын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Баян-Өндөр, Жаргалант сумдын багийн Засаг дарга, Иргэдийн Нийтийн хурлын дарга, Тэргүүлэгчид болон ажилтнуудад үе шаттайгаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэд, олон нийтэд хууль тогтоомж, хурал, захиргааны байгууллагаас зохион байгуулж буй ажлыг сурталчлах, сурталчилгааны гарын авлага, материалаар хангах зардлыг баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 30000000 /Гучин сая/ төгрөгийг төсөл, хөтөлбөрийн “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 06 сарын
07 өдрийн 4/3/12 захирамжийн хавсралт

БАГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗАРИМ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСВИЙН ТООЦОО

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /төг-өөр/
1.	Иргэд, олон нийтэд хууль тогтоомж шийдвэр болон орон нутгийн хурал захиргааны байгууллагаас зохион байгуулж байгаа ажлыг сурталчлах, мэдээлэл хүргэх	10000000
2.	Багийн Засаг дарга болон ажилтнууд туршлага судлах, сургалтанд оролцох	10000000
3.	Хөтөлбөрийн нээлт, сургалт, хэлэлцүүлэг хийх	1800000
4.	Багшийн хөлс, буудал, хоол, унааны зардал /3 удаагийн/	1100000
5.	Багуудын албан хэрэгцээнд - гарын авлага /ном, товхимол/	3500000
6.	Цайны завсарлага	1400000
7.	Хэлэлцүүлэг, сургалтанд оролцогсдод тараах материалууд	2200000
	Дүн	30000000